



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/78

Арвайхээр

Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 09/07 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засгийг 2014-2024 он хүртэл хөгжүүлэх бодлогын баримт бичиг”-ийн 3.1.4.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/772 дугаар захирамжийн 3 дахь хэсгийг “Хавсралтанд тусгагдсан 10990000 (арван сая есөн зуун ерэн мянга) төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтанд батлагдсан эвент арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй”-гэж өөрчлөн найруулсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100176